



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 382

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Үндэсний аврах бригадын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 20,602,248.50 (хорин сая зургаан зуун хоёр мянга хоёр зуун дөчин найман төгрөг тавин мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 2 ширхэг автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга Бригадын генерал Г.Ариунбуян, Үндэсний аврах бригадын захирагч хурандаа Д.Намсрай нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах,

2.3. Акталж, данснаас хассан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Наангэрэл) түүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

*D.Naran*

Д.НААНГЭРЭЛ

132001297

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2021 оны 09 дугаар сарын 08 өдрийн  
382 дугаар тогтоолын хавсралт

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Үндэсний аврах бригадын  
хөрөнгөд бүртгэлтэй акталж данснаас хасах автомашин

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Балансын үнэ, хууримтлагдсан элэгдэл
1	УАЗ Фургон, улсын дугаар 08-04 УБМ	1990/2005	1	13,157,248.50
2	Газ-53 улсын дугаар 53-10 УБС	1990/2005	1	7,445,000.00
Нийт дүн			2	20,602,248.50